

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ  
2023 ОНЫ НЭГДСЭН ТАЙЛАН

## АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	1
1.1.ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ.....	1
1.2. ХӨРВӨХ ЧАДВАР .....	2
1.3. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКСҮҮД .....	2
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ.....	3
2.1. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙЛҮҮЛЭЛТ.....	3
2.1.1. Хувьцааны арилжаа .....	3
2.1.2. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа.....	5
2.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа.....	6
2.1.4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа.....	7
2.1.5. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа .....	7
2.1.6. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа.....	8
2.2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ .....	10
2.2.1. Хөрөнгө оруулагчдын бүтэц .....	10
2.3. БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	10
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД.....	11
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ.....	13
4.1. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЭЧЛЭЛ .....	13
4.2. БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ, АРГАЧЛАЛЫН ШИНЭЧЛЭЛ .....	13
4.3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨРӨЛЖСӨН БАНКНЫ ЗОХИЦУУЛАЛТ .....	13
4.4. МЭРГЭЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫГ ДЭМЖИХ ХҮРЭЭНД .....	14
4.5. БАНКНЫ САЛБАРЫН РЕФОРМ.....	14
4.6. ХАМТЫН АЖИЛЛАГАА.....	14
4.7 УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖ.....	15


## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Олон улсын валютын сан, Дэлхийн банкнаас хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хөгжлийн түвшнийг үнэлж, тогтоох хүрээнд хөрөнгийн зах зээлийн хөгжлийн голлох үзүүлэлтүүд болох дараах индикаторуудыг оруулсан байдаг: зах зээлийн үнэлгээ, зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь, хөрвөх чадвар, хувьцааны индекс.

### 1.1. ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2023 оны жилийн эцсийн байдлаар 11.65 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.69 дахин өссөн бөгөөд уг үзүүлэлт 2023 оны урьдчилсан байдлаар тооцсон ДНБ-ний 17.8 хувьтай тэнцэж байна.

График 1. ДНБ-д харьцуулсан хөрөнгийн зах зээлийн үнэлгээ



Тайлбар: 2023 оны ДНБ гараагүй байгаа тул урьдчилсан байдлаар тооцож гаргасан болно.

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээг бүрдүүлж байгаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийт 175 компани болон 3 хамтын хөрөнгө оруулалтын сангаас дараах 30 компанийн зах зээлийн үнэлгээ 10.97 их наяд төгрөгийн үнэлгээтэй байгаа нь хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээний 94.2 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 1. Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 30 компани


№	Компанийн нэр	Эзлэх хувь	№	Компанийн нэр	Эзлэх хувь
1	“ХААН банк” ХК	19.76%	16	“Улсын Их Дэлгүүр” ХК	0.91%
2	“Худалдаа хөгжлийн банк” ХК	14.55%	17	“Ард санхүүгийн нэгдэл” ХК	0.86%
3	“АПУ” ХК	11.05%	18	“Монгол шуудан” ХК	0.72%
4	“Тавантолгой ХК	8.05%	19	“Монложистикс холдинг” ХК	0.61%
5	“Голомт банк” ХК	6.29%	20	“Түмэн шувуут” ХК	0.57%
6	“Хас банк” ХК	5.68%	21	“Гутал” ХК	0.56%
7	“Инвескор ББСБ” ХК	4.55%	22	“Тэнгэрлиг медиа групп” ХК	0.52%
8	“МИК холдинг” ХК	3.91%	23	“Газар шим үйлдвэр” ХК	0.51%
9	“Төрийн банк” ХК	3.62%	24	“Техник импорт” ХК	0.39%
10	“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” ХК	2.51%	25	“Мандал даатгал” ХК	0.38%
11	“Говь” ХК	1.83%	26	“Инновэйшн Инвестмент” ХК	0.38%
12	“Монгол даатгал” ХК	1.60%	27	“Монголын хөрөнгийн бирж” ХК	0.35%
13	“Сэнтрал экспресс си ви эс” ХК	1.04%	28	“Монос хүнс” ХК	0.35%
14	“Сүү” ХК	1.02%	29	“Лэндмн ББСБ” ХК	0.34%
15	“Богд банк” ХК	0.96%	30	Мандал ирээдүйн өсөлт	0.33%

Тайлбар: Зах зээлийн үнэлгээнд 100 хувь төрийн өмчит компанийн үнэлгээ ордоггүй болно.

## 1.2. ХӨРВӨХ ЧАДВАР

Тайлант хугацаанд хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.92 пунктээр буурч, 1.5 хувьд хүрсэн байна. Манай улсын хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар бага байгаа нь хувьцааны хэт төвлөрөлтэй холбоотой юм. Тухайлбал 2023 оны жилийн эцсийн байдлаар ТОП-20 индексэд багтах ХК-уудын хувьцааны төвлөрлийг тооцож үзэхэд хэт төвлөрөлтэй буюу нийт хувьцааны 77.42 хувийг 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна.

График 2. Хөрвөх чадвар (хувиар)



## 1.3. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКСҮҮД

“Монголын хөрөнгийн бирж” ХК-аас ТОП-20, MSE-A, MSE-B гэсэн гурван төрлийн хувьцааны үнийн индексүүдийг тооцон гаргадаг. ТОП-20 индексээр зах зээлийн үнэлгээ болон хувьцаа нь идэвхтэй арилжаалагддаг нэр бүхий 20 компанийн, MSE-A болон MSE-B индексээр үнэт цаасны бүртгэлийн I, II ангилалд багтсан компаниудын хувьцааны үнийн индексийг тус тус харуулдаг байна.

Хүснэгт 2. Индексийн үзүүлэлт

Индекс	2022	2023	Өөрчлөлт
ТОП 20	37,565.55	41,437.42	+10.31%
MSE A	14,137.94	17,574.53	+24.31%
MSE B	12,667.44	11,327.14	-10.58%

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

ТОП-20 индексийн дээд үзүүлэлт тайлант хугацааны байдлаар 41,437.42 нэгж, доод үзүүлэлт 34,218.33 нэгж, дундаж үзүүлэлт 36,777.17 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,871.87 нэгжээр буюу 10.31 хувиар өсөж, **41,437.42** нэгж болсон байна.

MSE-A индексийн дээд үзүүлэлт тайлант хугацааны байдлаар 19,652.35 нэгж, доод үзүүлэлт 14,088.84 нэгж, дундаж үзүүлэлт 15,803.7 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,436.59 нэгжээр буюу 24.31 хувиар өсөж, **17,574.53** нэгж болсон байна.

Харин MSE-B индексийн дээд үзүүлэлт 12,917.95 нэгж, доод үзүүлэлт 11,137.61 нэгж, дундаж үзүүлэлт 12,260.43 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,340.30 нэгжээр буюу 10.58 хувиар буурч, **11,327.14** нэгж болсон байна.


# ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ

## 2.1. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙЛҮҮЛЭЛТ

2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 787.16 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдсэнээс 732.28 тэрбум төгрөгийн арилжаа арилжаа эрхлэх байгууллагаар, 54.88 тэрбум төгрөгийн арилжаа хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангаар дамжуулан хийгдсэн байна.

Тайлант хугацаанд хувьцааны арилжаа түлхүү явагдсан бөгөөд нийт үнэт цаасны арилжааны 66.67 хувийг хувьцаа, 17.54 хувийг компанийн өрийн хэрэгсэл, 8.07 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 7.73 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа тус тус эзэлж байгаа бөгөөд нийт үнэт цаасны арилжааны хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.32 дахин өссөн үзүүлэлттэй байна.

График 3. Үнэт цаасны арилжааны хэмжээ (бүтээгдэхүүний төрөл, хувиар)




Харин Хөдөө аж ахуйн биржээр тайлант хугацаанд 221 удаагийн цахим арилжаа зохион байгуулагдсан ба нийт 968.3 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан бол Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 299 удаагийн арилжаа зохион байгуулагдаж нийт 7.54 их наяд төгрөгийн уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалагдсан байна.

### 2.1.1. Хувьцааны арилжаа

График 4. Хувьцааны арилжаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд нийт 524.76 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 52.8 хувиар буюу 1.5 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Үүнээс хувьцааны анхдагч зах зээлд нийт 350.04 тэрбум төгрөгийн, хоёрдогч зах зээлд нийт 174.72 тэрбум



Хоёрдогч зах зээл дээрх хувьцааны арилжааг арилжаа эрхлэх байгууллага дээр бүртгэлтэй, арилжааны хэмжээгээрээ тэргүүлэгч 30 компанийн арилжааны мэдээллийг үнийн дүнгээр харуулбал:

*Хүснэгт 3. Арилжааны хэмжээ хамгийн өндөр 30 компанийн арилжааны үнийн дүн (тэрбум төгрөгөөр)*

№	Компанийн нэр	Үнийн дүн	№	Компанийн нэр	Үнийн дүн
1	“Инвекор ББСБ” ХК	20.49	16	“Талх Чихэр” ХК	1.48
2	“ХААН” ХК	14.7	17	“Ард Кредит ББСБ” ХК	1.35
3	“АПУ” ХК	13.2	18	“Төрийн Банк” ХК	1.34
4	“Худалдаа хөгжлийн Банк Банк” ХК	11.13	19	“Ард Даатгал” ХК	1.25
5	“Голомт Банк” ХК	10.7	20	“Түмэн шувуут” ХК	1.24
6	“Ард санхүүгийн нэгдэл” ХК	6.73	21	“Монос Хүнс” ХК	1.03
7	“Монголын хөрөнгийн бирж” ХК	6.52	22	“Мандал Даатгал” ХК	0.83
8	“Богд Банк” ХК	5.99	23	“Монложистикс Холдинг” ХК	0.67
9	Мандал ирээдүйн өсөлт	4.04	24	“Монгол Шуудан” ХК	0.66
10	“Говь” ХК	4.00	25	“ЛэндМН ББСБ” ХК	0.65
11	“Сентрал экспресс Си Ви Эс” ХК	3.96	26	“Крипто Үндэстэн” ХК	0.62
12	“Таван Толгой” ХК	3.07	27	“Сүү” ХК	0.59
13	“Сэндли ББСБ” ХК	2.46	28	“Хас банк” ХК	0.55
14	“Атар-Өргөө” ХК	2.26	29	“Газар шим үйлдвэр” ХК	0.53
15	“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” ХК	2.23	30	“Хорин хоёрдугаар бааз” ХК	0.51
<b>НИЙТ</b>					<b>170.47</b>

### 2.1.1.1. Багцын арилжаа

Тайлант хугацаанд нийт 24 хувьцаат компанийн 114.22 сая ширхэг буюу 76.1 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий багцын арилжаа хийгдсэн нь нийт хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны 43.5 хувийг эзэлж байна.

*Хүснэгт 4. Багцын арилжаа хийгдсэн компаниуд*

№	Үнэт цаасны нэр	Арилжаалагдсан ширхэг (мянган ширхэг)	Үнийн дүн (тэрбум төгрөг)
1.	“Ард санхүүгийн нэгдэл” ХК	591.71	1.84
2.	“Ард кредит ББСБ” ХК	4,403.69	0.57
3.	“Хорин хоёрдугаар бааз” ХК	213.42	0.50
4.	“Ард Даатгал” ХК	933.76	0.85
5.	“АПУ” ХК	8,543.93	9.18
6.	“Бодь Даатгал” ХК	4,033.58	0.50
7.	“Богд банк” ХК	35,159.93	3.75
8.	“Крипто үндэстэн” ХК	5.85	0.30
9.	“Сентрал экспресс Си Ви Эс” ХК	10,817.31	2.49
10.	“Голомт Банк” ХК	4,176.95	5.31
11.	“Говь” ХК	9,292.73	3.07
12.	“Инвекор ББСБ” ХК	4,955.89	28.43
13.	“ХААН Банк” ХК	2,299.98	2.59
14.	“Монложистикс Холдинг” ХК	5,465.26	1.02
15.	“Мандал Даатгал” ХК	10,542.76	0.70
16.	“Мандал говь импекс” ХК	52.61	0.03

17.	“Монгол шуудан” ХК	471.26	0.41
18.	“Монголын хөрөнгийн бирж” ХК	1,691.34	0.25
19.	“Сэндли ББСБ” ХК	8,666.67	1.64
20.	“Сүү” ХК	1,381.20	0.54
21.	“Тахь-Ко” ХК	48.81	0.44
22.	“Худалдаа Хөгжлийн Банк” ХК	376.52	11.40
23.	“Тавантолгой” ХК	23.57	0.28
24.	“Өлзий-Дундговь” ХК	73.83	0.01
<b>ДҮН</b>		<b>114,222.57</b>	<b>76.11</b>

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

## 2.1.2. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа

График 5. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд компанийн өрийн хэрэгслийн нийт арилжаа 138.08 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.0 хувиар өссөн үзүүлэлт юм.

Компанийн өрийн хэрэгслийн анхдагч зах зээлд нийт 107.5 тэрбум төгрөг, хоёрдогч зах зээлд нийт 30.58 тэрбум төгрөгийн арилжаа тус тус хийгдсэн байна.



Хороо тайлант хугацаанд 7 компанийн гаргаж буй өрийн хэрэгслийг бүртгэсэн. Үүнд:

- “Сэндли ББСБ” ХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 85,000 ширхэг өрийн хэрэгслийг бүртгэсэн.
- “Бизнес-Инвест девелопмент ББСБ” ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 80,000 ширхэг өрийн хэрэгслийг бүртгэсэн.
- “ХААН банк” ХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 170,000 хүртэл ширхэг, нэг бүр нь 100 ам.долларын нэрлэсэн үнэ бүхий 250,000 хүртэл ширхэг өрийн хэрэгслийг бүртгэсэн.
- “Ашид капитал ББСБ” ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 200,000 ширхэг өрийн хэрэгслийг бүртгэсэн.
- “Лэндмн ББСБ” ХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 90,000 ширхэг өрийн хэрэгслийг бүртгэсэн.
- Нийслэлийн засаг даргын хөтөлбөрийн хүрээнд нийтэд санал болгон гаргаж буй нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 5,000,000 хүртэл ширхэг өрийн хэрэгслийг бүртгэсэн.
- “Ашид капитал ББСБ” ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 150,000 ширхэг өрийн хэрэгслийг бүртгэсэн.

### 2.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа


Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль батлагдсанаас хойш 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 36 компани хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байна.

Тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооноос 2 компанид хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон байна. Үүнд:

- “Ашид ассет менежмент ҮЦК” ХХК-ийн үүсгэн байгуулсан “Ашид арвижих” хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сан нэгж эрхийн анхдагч зах зээлд арилжих ажиллагааг амжилттай зохион байгуулж, 10,121,444 ширхэг нэгж эрхийг нэг бүрийг 100 (нэг зуун) төгрөгөөр олон нийтэд санал болгон арилжаалж, нийт 1,012,144,400 төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.
- “Инвескор ассет менежмент ҮЦК” ХХК-ийн үүсгэн байгуулж буй “Инвескор Глобал Кью” хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн үүсгэн байгуулах баримт бичиг болон сангийн нэгж эрхийн танилцуулгыг бүртгэж, тус сан нэгж эрхийн анхдагч зах зээлд арилжих ажиллагааг амжилттай зохион байгуулж, 840,492 ширхэг нэгж эрхийг нэг бүрийг 500 (таван зуун) төгрөгөөр олон нийтэд санал болгон арилжаалж, нийт 420,246,000 төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Харин 10 компанийн хувийн хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэж, улмаар тус хувийн сангууд үүсгэн байгуулагдсан байна.

График 6. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа (тэрбум төгрөгөөр)



Тайлант хугацаанд хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн анхдагч зах зээлд нийт 1.43 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн бол хоёрдогч зах зээлд нийт 59.38 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж нийт 60.82 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 4.5 дахин өссөн дүн юм.

График 7. Тайлант хугацаанд хийгдсэн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжааны задаргаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлд нийт 60.82 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэнээс хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангаар 5.94 тэрбум төгрөгийн арилжаа, хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангаар 54.88 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь тус тус нийт арилжааны 9.7 болон 90.3 хувийг бүрдүүлж байна.




#### 2.1.4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа

Тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооноос 10 компанид хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосноос 8 компанийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэсэн байна. Үүнд:

- 2023 оны 778, 779 дүгээр тогтоолоор тус тус "БИД ассет" ХХК, "Бичил Эй Би Эс лоялти" ХХК-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол 88, 151, 181, 209, 552, 553, 554, 777 дугаар тогтоолоор тус тус "Бэрс Эй Би Эс плас ТЗК" ХХК, "ҮЦСК Актив тав ТЗК" ХХК, "Бичил Эй Би Эс плас ТЗК" ХХК, "МИК актив гучин гурав ТЗК" ХХК, "Омни ассет ТЗК" ХХК, "ҮЦСК актив зургаа ТЗК" ХХК, "МИК актив гучин дөрөв ТЗК" ХХК, "Бэрс Эй Би Эс лоялти ТЗК" ХХК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэсэн байна.

График 8. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа (тэрбум төгрөгөөр)




Тайлант хугацаанд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаагаар 35.0 тэрбум төгрөгийн арилжаа, хоёрдогч зах зээлд нийт 28.5 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж, нийт 63.5 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 1.6 дахин буюу 38.8 хувиар буурсан үзүүлэлт юм.

#### 2.1.5. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа

Тайлант хугацаанд Хөдөө аж ахуйн бирж нь 221 удаагийн цахим арилжаа зохион байгуулан 1,662 хэлцлээр нийт 968.3 тэрбум төгрөгийн үнэ бүхий бараа, түүхий эдийн арилжаа хийсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 141.7 тэрбум төгрөгөөр буюу 12.8 хувиар буурсан үзүүлэлт юм.

График 9.ХААБ-ээр арилжаалагдсан түүхий эдийн арилжаа (тэрбум төгрөгөөр)



ХААБ-ээр дараах төрлийн бүтээгдэхүүнүүд арилжаалагдсан байна. Үүнд:

Зураг 1. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа



Хүснэгт 5. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны дүн (бүтээгдэхүүний төрлөөр)

Ямааны ноолуур	854,977,444,800.00	Нийт арилжааны дийлэнх хувийг буюу 88.3 хувийг ямааны ноолуур, 5.24 хувийг завод ноос, 3.8 хувийг тосны ургамал, 1.8 хувийг хонины ноос, 0.84 хувийг тэмээний ноос тус тус эзэлж байгаа бол үлдсэн хэсэг болох 0.02 хувийг бодын хөөвөр болон арьс шир бүрдүүлж байна.
Хонины ноос	17,458,487,000.00	
Завод ноос	50,768,425,000.00	
Тэмээний ноос	8,091,310,000.00	
Тосны ургамал (рапс)	36,752,440,000.00	
Бодын хөөвөр	206,000,000.00	
Арьс шир	13,200,000.00	
<b>Нийт</b>	<b>968,267,306,800.00</b>	

### 2.1.6. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа

Улсын Их хурлаас баталсан Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль мөрдөгдөж эхлэх хүртэлх хугацаанд Засгийн газрын 2022 оны 466 дугаар тогтоолоор баталсан "Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам"-ын дагуу 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн нүүрсний цахим арилжааг "Монголын хөрөнгийн бирж" ХК-аар дамжуулан нээлттэй арилжаалж эхэлсэн.

Түүнчлэн Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос "Монголын хөрөнгийн бирж" ХК-д уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосны үндсэн дээр тус бирж уул уурхайн бүтээгдэхүүний арилжааг зохион байгуулж байна.

2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөс хойш хойш 2023 оныг дуусталх хугацаанд 204 удаагийн арилжаагаар 14.94 сая тонн нүүрсийг 7.34 их наяд төгрөгөөр, 95 удаагийн арилжаагаар 677.45 мянган тонн төмрийн хүдэр, баяжмалыг 196.2 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалж, нийт 299 удаагийн арилжаагаар 15.61 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг 7.54 их наяд төгрөгөөр арилжаалсан байна.


Манай улсын хувьд 2023 оны байдлаар нийт 69.6 сая тонн нүүрс болон 5.7 сая тонн төмрийн хүдэр баяжмалыг экспортолсон байна. Үүнээс нүүрсний экспортын 21.5 хувь, төмрийн хүдэр, баяжмалын 11.7 хувийг тус тус уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалсан байна.

Хүснэгт 6. УУББ-ээр дамжсан уул уурхайн бүтээгдэхүүний экспортын дүнд эзлэх хувь

Экспортын хэмжээ, бүтээгдэхүүний төрлөөр /сая.тонн/	2023-Нийт	2023-УУББ арилжаалсан	Эзлэх хувь
Нүүрсний	69.6	14.94	21.5%
Төмрийн хүдэр, баяжмал	5.7	0.67	11.7%

Эх сурвалж: Уул уурхай хүнд, үйлдвэрийн яам


График 10. Нийт арилжаалагдсан нүүрсний хэмжээ (төрөл, ангилал, хувиар)



Тайлант хугацаанд нийт 9 төрлийн 14.94 сая тонн нүүрс арилжаалагдсанаас 1/3 коксжих нүүрс 19.67 хувийг, баяжуулсан коксжих нүүрс 9.85 хувийг, баяжуулсан дунд зэрэг үнстэй хагас хатуу коксжих нүүрс 1.03 хувийг, баяжуулсан сул коксжих нүүрс 0.94 хувийг, дэгдэмхий бодис дундаас их, хийн нүүрс 0.73 хувийг, дэгдэмхий бодис дунд, коксжих нүүрс 59.0 хувийг, эрчим хүчний нүүрс 7.2 хувийг, хатуу коксжих нүүрс 1.5 хувийг, чийг багатай хүрэн нүүрс 0.09 хувийг тус тус эзэлж байна.

График 11. Нийт арилжаалагдсан төмрийн хэмжээ (төрөл, ангилал, хувиар)

Тайлант хугацаанд нийт 677.45 мянган тонн төмрийн хүдэр, баяжмал арилжаалагдсанаас 33.77 хувийг Fe-52%-ийн агууламжтай төмрийн хүдэр, 35.24 хувь Fe-58%-ийн агууламжтай төмрийн баяжмал, 31.0 хувийг Fe-65%-ийн агууламжтай төмрийн баяжмал тус тус бүрдүүлж байна.




## 2.2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ

Тайлант хугацаанд **109,320** шинэ данс, **59,700** холболтын данс шинээр нээгдэж өссөн дүнгээр нийт **2,555,610** данс, **627,601** холболтын данс “ҮЦТХТ” ХХК-д бүртгэлтэй байна.

### 2.2.1. Хөрөнгө оруулагчдын бүтэц

График 12. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын арилжааны үнийн дүнд эзлэх хувь



Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн нийт хоёрдогч зах зээлийн арилжаанд дотоодын иргэний хийсэн арилжаа 118.93 тэрбум төгрөг (49.54 хувь), дотоодын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа 116.06 тэрбум төгрөг (48.34 хувь), гадаадын иргэний хийсэн арилжаа 2.03 тэрбум төгрөг (0.85 хувь), гадаадын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа 3.05 тэрбум төгрөг (1.27 хувь)-ийг тус тус эзэлж нийт 240.07 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

Эх сурвалж: “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК

Дээрх арилжаанд давтагдсан тоогоор нийт 111,489 хүн оролцож, 273,408 удаагийн арилжаа хийсэн байна. (Дэлгэрэнгүйг доорх хүснэгтээс харна уу.)

Хүснэгт 7. Хөрөнгө оруулагчдын бүтэц (давтагдсан тоо, хувиар)

	Арилжаанд оролцогчийн тоо		Арилжаанд оролцсон тоо	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Гадаадын ААН	235	0.21%	1,586	0.58%
Гадаадын иргэн	723	0.65%	2,150	0.79%
Дотоодын ААН	2,188	1.96%	21,444	7.84%
Дотоодын иргэн	108,343	97.18%	248,228	90.79%
<b>Нийт</b>	<b>111,489</b>	<b>100%</b>	<b>273,408</b>	<b>100%</b>

Эх сурвалж: “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК

## 2.3. БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Биржийн бус зах зээлийн үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс 2023 оны жилийн эцэс хүртэлх хугацаанд биржийн бус зах зээлд төгрөгөөр нийт 93 компанийн нийт 2.44 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 151 өрийн хэрэгсэл гарсан бөгөөд 1.74 их наяд төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн байна. Харин доллароор нийт 71.0 сая ам.долларын үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл бүртгэгдсэнээс 45.0 сая ам долларыг амжилттай татан төвлөрүүлсэн байна.

Үүнээс тайлант хугацаанд 63 үнэт цаас гаргагчийн 1.06 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий, 195 транч өрийн хэрэгслийг бүртгэсэнээс 829.45 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн бол доллароор 59 сая ам.долларын үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл бүртгэгдсэнээс 33.5 сая ам.долларыг амжилттай татан төвлөрүүлсэн байна.

График 13.. Тайлант хугацаанд ББЗЗ-д бүртгэгдсэн нийт өрийн хэрэгслийг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны салбараар ангилсан тоон мэдээлэл (хувиар)

Тайлант хугацаанд бүртгэгдсэн нийт өрийн хэрэгслийн татан төвлөрүүлэхээр зарласан дүнг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны салбараар нь ангилбал уул уурхай 4.0 хувь, банк бус 41.0 хувь, үл хөдлөх 18.0 хувь, санхүү 9.0 хувь, гадаад худалдаа борлуулалт 11.0 хувь, худалдаа, үйлдвэрлэл 10.0 хувь, бусад салбар 7.0 хувийг бүрдүүлж байна.



### ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД

Өнөөдрийн байдлаар үнэт цаасны зах зээл дээр Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Инновацийн тухай хууль зэрэг хуулиуд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Эдгээр хууль болон бусад холбогдох дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд хяналт тавих, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлж байна.

Дээрх хууль тогтоомжийн хүрээнд тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл болон бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж буй 292 зохицуулалттай этгээд байна.

Хүснэгт 8. Үнэт цаасны зах зээлд оролцогчид

№	Үйл ажиллагааны төрөл	Тоо
<b>Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэгч</b>		
1	Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага	3
2	Үнэт цаасны тооцооны байгууллага	2 <sup>1</sup>
3	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага	1
4	Үнэт цаасны төлбөрийн байгууллага	1 <sup>2</sup>
5	Хөрөнгө оруулалтын менежментийн компани	36
6	Хамтын хөрөнгө оруулалтын сан /хаалттай, нээлттэй/	6
7	Кастодиан банк	3
8	Үнэт цаасны компани	52
	Брокер	51
	Үүнээс:	
	Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэгч	16
	Номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээний үйлчилгээ үзүүлэгч	17
Дилер		34

<sup>1</sup> Тус тоонд үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болох “Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК болон “МУЦКТ” ХХК орсон болно.

<sup>2</sup> “УЦТХТ” ХХК нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн болон төлбөрийн үйл ажиллагааг үзүүлдэг.

	Андеррайтер	22 <sup>3</sup>
	Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлэгч	20
9	Хөрөнгө итгэмжлэн удирдагч	8
10	Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч	1
11	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөлтэй компани	59 <sup>4</sup>
12	ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага	1
13	ХАА-н биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага	10
14	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага	1*
15	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч /брокер/	3*
16	Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох байгууллага	1
<b>Бүртгэлтэй хөндлөнгийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд</b>		
17	ҮЦЗЗ-д оролцогчид аудитын үйлчилгээ, хөрөнгийн үнэлгээ үзүүлэгч байгууллага	65 <sup>5</sup>
	Аудитын үйлчилгээ үзүүлэгч байгууллага	49
	Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч байгууллага	24
18	ҮЦЗЗ-д оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэгч байгууллага	43
<b>Нийт (ТЗ болон бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж буй компаниудын тоо)</b>		<b>292</b>

Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийт 175 ХК байна. Мөн Хорооны 2015 оны 06-р сарын 10-ны өдрийн 273 дугаар тогтоолоор “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо” ГҮТББ-ыг, 2015 оны 10-р сарын 13-ны өдрийн 379 дүгээр тогтоолоор “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийг өөрийгөө зохицуулах байгууллагаар тус тус бүртгэсэн.

*Хүснэгт 9. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй ХК-ийн тоо болон зах зээлийн үнэлгээ*

Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын нэр	Бүртгэлтэй ХК-ийн тоо	Зах зээлийн үнэлгээ 2023 он
1) “Монголын хөрөнгийн бирж” ХК <i>-100 хувь төрийн өмчит -Төрийн өмчийн оролцоотой -Бусад</i>	<b>173</b> 4 11 158	11,620,235,212,747.80 ₮ <i>(Тус биржийн зах зээлийн үнэлгээнд 100 хувь төрийн өмчит компанийн үнэлгээ ордоггүй болно.)</i>
2) “Улаанбаатар үнэт цаасны бирж” ХК	<b>2</b>	29,947,971,468.00 ₮
3) “Чингис хаан хөрөнгийн бирж” ХХК	-	-

<sup>3</sup> Тус тоонд андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 2 банк /“Голомт банк” ХК, “Тээвэр Хөгжлийн банк” ХХК/ орсон болно.

<sup>4</sup> Тус тоонд “МИК ОССК” ХХК-34, “ҮЦСК” ХХК-6, “Носк тав ТЗК” ХХК-5, нээлттэй хүрээнд ХБҮЦ гаргасан 13 ТЗК, хаалттай хүрээнд гаргасан 1 ТЗК тус тус орсон.

<sup>5</sup> ҮЦЗЗ-д оролцогчид аудитын үйлчилгээ, хөрөнгийн үнэлгээ үзүүлэх үйлчилгээг зэрэг үзүүлдэг 8 компани байна.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ**

Санхүүгийн зохицуулах хорооноос 2023 онд Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлд голчлон анхаарч дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

### **4.1. Хууль, эрх зүйн орчны шинэчлэл**

Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо хариуцан боловсруулахаар тусгасан. Энэ хүрээнд Сангийн сайдын 2021 оны 52 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Хөрөнгийн зах зээлийн холбогдох хууль эрх зүйн орчин шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий” ажлын хэсгээс боловсруулсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлэх Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Засгийн газар хэлэлцэж, Улсын Их Хуралд 2023 оны 12 дугаар сард өргөн мэдүүлсэн.



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар дотоодын аж ахуйн нэгжээс нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагаа хялбар, шуурхай болж, зохицуулагч болон арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн хоорондын уялдаа холбоо сайжран олон улсын жишигт нийцэх, санхүүгийн технологид

суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэмэгдэх, үнэт цаас гаргагч, андеррайтерийн компаниудын үүрэг оролцоо өсөх, үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, төвлөрсөн болон тухайлсан бүртгэлтэй холбоотой зохицуулалт боловсронгуй болох зэрэг эерэг нөлөө хөрөнгийн зах зээлд бий болох ач холбогдолтой юм.

### **4.2. Бизнесийн үнэлгээ хийх журам, аргачлалын шинэчлэл**

Улсын Их Хурлаас 2022 оны 06 дугаар сард Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсантай холбогдуулан Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2011 оны 274/240 тоот хамтарсан тушаалаар баталсан “Бизнесийн үнэлгээ хийх аргачлал”-ыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн батлах шаардлага үүссэн. Энэ хүрээнд Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны А/144/348 дугаар хамтарсан тушаалаар “Бизнесийн үнэлгээ хийх журам” болон “Бизнесийн үнэлгээ хийх аргачлал”-ыг тус тус баталсан.

### **4.3. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны зохицуулалт**

Улсын Их Хурлаас 2023 оны 01 дүгээр сард Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийг баталсан. Үүнтэй холбогдуулан тус хуульд батлахаар дараах 3 журам болон хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны зээл, зээлийн үйл ажиллагаанд баримтлах шаардлагыг Монголбанкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны А-164/386, А-165/385 дугаар хамтарсан тушаалаар баталсан.

- Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны худалдах, худалдан авах үнэт цаас, санхүүгийн хэрэгслийн төрөл, хэмжээг тогтоох, хэлцэл хийхэд баримтлах журам
- Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон хязгаарлалтыг тогтоох, түүнд хяналт тавих журам
- Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам
- Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкнаас олгох зээлд баримтлах шаардлага

#### 4.4. Мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг дэмжих хүрээнд

Хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалтын орчныг сайжруулах, зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй хөрөнгө оруулалтын менежментийн компаниуд, хамтын хөрөнгө оруулалтын сангуудын үйл ажиллагаанд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор Хорооны 2023 оны 464 дүгээр тогтоолоор “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”-ын хамтын сангийн активт тавих шаардлагыг хөнгөвчилсөн өөрчлөлтийг баталсан.

#### 4.5. Банкны салбарын реформ

Улсын Их Хурлаас 2021 онд баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд зааснаар системд нөлөө бүхий банкууд компанийн хэлбэрийг өөрчлөн зохион байгуулж, хөрөнгийн зах зээл дээр олон нийтэд хувьцаа гаргах замаар 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор нээлттэй хувьцаат компани болох, мөн хувьцаа эзэмшлийн төвлөрлийг 20 хувиас хэтрүүлэхгүй байх шаардлагыг 2023 оны

12 дугаар сарын 31-ний өдрийн дотор хангах үүргийг тус тус хүлээсэн.

Хорооны зүгээс Банкны салбарын реформын хүрээнд банкны системд нөлөө бүхий банкнуудын нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргах ажиллагааг амжилттай хэрэгжүүлж, нээлттэй хувьцаат компани хэлбэртэй болох хуулийн шаардлагыг хангуулах хүрээнд зохицуулалтын орчныг боловсронгуй болгож, олон улсын жишигт нийцүүлэхийн зэрэгцээ нийтэд санал болгон үнэт цаас гаргахтай холбогдуулан зөвлөгөө мэдээлэл өгөх, зохицуулалтын бодлогоор тухай бүр дэмжлэг үзүүлэн ажиллалаа.




Үүний үр дүнд “Богд банк” ХК болон системд нөлөө бүхий 5 банк болох “Төрийн банк” ХК, “Голомт банк” ХК, “ХААН банк” ХК, “Худалдаа Хөгжлийн банк” ХК, “Хас банк” ХК-ийн IPO хийх ажиллагаа амжилттай хэрэгжсэн. Нийт давтагдсан тоогоор 72 мянга гаруй хөрөнгө оруулагчдаас 478.54 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлснээс гадна зах зээлийн үнэлгээг 5.86 их наяд төгрөгөөр нэмэгдүүлсэн.

#### 4.6. Хамтын ажиллагаа

Санхүүгийн зохицуулах хороо Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран ТОП-100 аж ахуйн нэгжүүдийг хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор “ТОП-100 аж ахуйн нэгжийн хөрөнгийн зах зээл дэх оролцоог өсгөх арга хэмжээний хөтөлбөр”-

ийг 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдөр баталсан.



Энэхүү хөтөлбөрийн хүрээнд ТОП-100 аж ахуйн нэгжүүд хөрөнгийн зах зээлд IPO хийх, компанийн бонд гаргахад тавих нөхцөл, шаардлага, цаг хугацаа, өртгийг бууруулж, IPO хийхэд хөрөнгийн үнэлгээ хийлгэхийг шаардахгүй байх, мөн нээлттэй, хаалттай хүрээнд бонд гаргахад барьцаа, батлан даалт шаардахгүй байх гэх зэргээр үнэт цаас гаргах ажиллагааг хялбаршуулах зохицуулалтуудыг “Үнэт цаасны бүртгэлийн журам”, “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам” болон “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-д тус тус тусгаж, нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Түүнчлэн ТОП-100 аж ахуйн нэгжүүдэд IPO хийх, компанийн бонд гаргахтай холбоотой холбогдох дүрэм, журмын талаарх ойлголт, мэдээллийг өгөх сургалт, арга хэмжээг шат дараалалтай зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Уг хөтөлбөрийн хүрээнд ТОП-100 аж ахуйн нэгжүүд нь IPO хийх замаар нээлттэй хувьцаат компани болох, компанийн бонд гаргаж санхүүжилт татах замаар хөрөнгийн зах зээлд оролцсоноор бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлж, ашиг, орлогоо өсгөх, компанийн нэр хүндээ өсгөх, урт хугацааны хямд санхүүжилтийн эх үүсвэр татах, компанийнхаа засаглал, мэдээллийн ил тод

байдлыг сайжруулах зэрэг чухал ач холбогдолтой юм.

#### 4.7. Уул уурхайн бүтээгдэхүүний бирж

Улсын Их Хурлаас 2022 оны 12 дугаар сард Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг баталсан. Үүнтэй холбогдуулж Хороо дараах журмуудыг баталж, захиргааны хэм хэмжээний актад бүртгүүлэн уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

- Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн болон биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам
- Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа төлбөр, тооцоо хийх ерөнхий журам
- Үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргагчид тавих нөхцөл, шаардлага, шалгуур болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт, түүнийг арилжих журам
- Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны болон ханшийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, ашиглах, мэдээллийг нийтэд хүргэх журам

Үүний сацуу Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд зааснаар уул уурхайн бүтээгдэхүүний бирж нь үйл ажиллагаандаа дагаж мөрдүүлэхээр 11 харилцааг зохицуулсан журмуудыг баталж, Хорооны зөвшөөрлөөр үйл ажиллагаандаа дагаж мөрдөхөөр заасны дагуу “Монголын хөрөнгийн бирж” ХК-аас нэр бүхий 7 журмыг баталж, Хорооны 387, 458, 465 дугаар тогтоолоор тус журмуудыг мөрдүүлэхийг зөвшөөрсөн.



Түүнчлэн Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд зааснаар биржийн үйлчилгээний хураамжийг биржээс ирүүлсэн санал, судалгааг харгалзан Хороо тогтоохоор заасан бөгөөд үүний дагуу Хорооны 2023 оны 386, 793 дугаар тогтоолоор “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйлчилгээний хураамж”, “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйлчилгээний төлбөр, хураамж”-ийг тогтоосон.

Засгийн газрын 2023 оны 223 дугаар тогтоолоор уул уурхайн бүтээгдэхүүний биржээр боловсруулаагүй нүүрс, баяжуулсан нүүрс, төмөр болон хайлуур жоншны хүдэр, баяжмалыг арилжаалахаар шийдвэрлэсэн ба дээрх бүтээгдэхүүнүүд “Монголын хөрөнгийн бирж” ХК-аар амжилттай арилжаалагдаж байна. Тухайлбал 2023 онд тус биржээр нийт 15.6 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг 7.54 их наяд төгрөгөөр арилжаалсан байна.

Уул уурхайн бүтээгдэхүүн биржээр дамжуулан арилжаалагдаж эхэлснээр арилжаа олон нийтэд нээлттэй, шударга, ил тод зохион байгуулагдаж, бүтээгдэхүүн үнийн өсөлттэй арилжаалагдах, экспортыг нэгдсэн бодлогоор хангах зэрэг олон давуу тал бий болоод байна.

## ҮНЭТ ЦААСНЫ ГАЗАР

---o-0-o---